

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын огноо: 2020 оны 4 сарын 27-ны өдөр;

Хурлын байршил: live.ard.mn сайтаар дамжуулан;

Хурал эхэлсэн цаг: 14 цаг 10 минут;

Хурлын дарга: Ард Санхүүгийн Нэгдлийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /Цаашид “ТУЗ” гэх/-ийн гишүүн О.Одбаяр;

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;

Хурлын ирц: 238,600,207 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн 85.21%-ийн ирцтэй

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Сайн байцгаана уу. 2019 оны Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болсон байна. Миний бие Унгар улсын Будапешт хотоос мэндчилж байна. Коронавирусын тархалт өндөр байгаа энэ үед Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудыг онлайнаар хурлаа зохион байгуулах чиглэл өгсний дагуу Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвлөмж аван хурлыг онлайнаар зохион байгуулж байна. Компанийн ТУЗ цар тахлын энэ үед үйл ажиллагаагаа илүү нягт нямбай явуулан, Гүйцэтгэх захиралтайгаа цаг тухай бүр хамтран ажиллаж байна. Энэхүү цар тахлын улмаас би хуралд биечлэн оролцох боломжгүй болж Унгар хотоос холбогдож байна. Хуралдаа идэвхитэй оролцож байгаа та бүхэндээ талархал илэрхийлээд Хурлыг даргалах үүргийг Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн гишүүн О.Одбаярт шилжүүлж байна.

Хурлын дарга О.Одбаяр: Ард Кредит ББСБ ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг онлайнаар, ТУЗ-ийн гишүүн Санхүү, зээл, эрсдэлийн хорооны дарга Ч.Ганзориг, ТУЗ-ийн ердийн гишүүн Засаглал, нэр дэвшүүлэх хорооны дарга В.Баяржаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүн Дотоод аудитын хорооны дарга Б.Ганбат, ТУЗ-ийн хараат бус гишүүн И.Баттуяаг төлөөлж Б.Өлзийбаяр, ТУЗ-ийн ердийн гишүүн М.Тулгат, Тооллогын комиссоор Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК ажиллаж байгаа бөгөөд Тооллогын комиссын дарга Г.Алтансүх, Тооллогын комиссын гишүүн Б.Мөнхзул, Б.Ариунзул, Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн, Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал Г.Сүхбаатар, Ерөнхий нягтлан бодогч Д.Дархижав, Судалгаа, шинжилгээний албаны менежер Ч.Гэндэнпил, Санхүүгийн шинжээч О.Аюушжав, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Мөнхсүрэн нар оролцож байна. Ингээд хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга Г.Алтансүхийг хувьцаа хурлын ирцийг танилцуулна уу хэмээн урьж байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол Хувьцаа эзэмшигчдийн ирцийн баталгаажилт: Тооллогын комиссын дүгнэснээр Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2, 67.3 дэх хэсгийг үндэслэн нийт саналын эрхтэй 280,000,000 ширхэг хувьцаанаас компанийн саналын эрх бүхий энгийн хувьцааны 238,600,207 ширхэг буюу 85.21 хувийг эзэмшиж байгаа хувьцаа



эзэмшигчдийн хурлын ирцтэй байна. Уг хувьцаа эзэмшигчид нь Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах санал хураалтад оролцоно.

Хурал даргалагч О.Одбаяр: Өнөөдрийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд Нэгдүгээрт, Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, Хоёрдугаарт, Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах асуудлуудыг хэлэлцэж, асуулт, хариулт, санал хураалтын үе явагдаж, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулах гэсэн дэгийн дагуу хурал явагдана. Хэлэлцэх асуудлын дэгтэй холбоотой заалнаас болон хувьцаа эзэмшигчдээс санал хүсэлт ирээгүй тул дээрх дэгийн дагуу хурлыг явуулахаар боллоо. Ингээд нэгдүгээр хэлэлцэх асуудлын хүрээнд танилцуулга хийнэ үү хэмээн ТУЗ-ийн хараат бус гишүүн, дотоод аудитын хорооны дарга Б.Ганбатыг урьж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн, дотоод аудитын хорооны дарга Б.Ганбат: Ард Кредит ББСБ ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийнханд энэ өдрийн мэнд хүргэхийн ялдамд та бүхэнд болон та бүхний гэр бүлд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье. Миний бие Б.Ганбат нь тус компанийн ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны даргаар ажилладаг. Танилцуулга маань 2 хэсгээс бүрднэ. Үүнд:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан,
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлийг батлах асуудлыг танилцуулна.

Төлөөлөн удирдах зөвлөл маань 1 жилийн өмнө томилогдож байсан. ТУЗ маань 9 гишүүдээс бүрдэж байгаа бөгөөд бизнесийн байгууллага, боловсролын байгууллагын төлөөллүүд ажилладаг мөн ТУЗ маань Санхүү, зээл, эрсдэлийн хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Дотоод аудитын хороонуудтай бөгөөд тайлант онд ээлжит хурал 4, эцнээ хурал 12 удаа зохион байгуулагдаж, нийт 16 удаа хуралдан 32 асуудал шийдвэрлэсэн байна. Ийнхүү компанид ТУЗ-ийн оролцоо өндөр байгаа нь Нээлттэй хувьцаат компани болсны хувьд Хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргийг биелүүлж байгаа явдал юм. Өнгөрсөн жилийн хувьд нийгэм, эдийн засгийн хувьд ололт амжилт их байсан хэдий ч цар тахалтай холбоотой асуудал үүсч эхэлсэн тул ТУЗ-ийн дэргэдэх Хороод болон Гүйцэтгэх удирдлага нягт уялдаа холбоотой ажиллаж байна. Тайлант онд компани 2.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд үүний 50 хувийг ногдол ашиг хэлбэрээр тараахаар шийдвэрлэж, нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 3.9 төгрөг, ногдол ашиг тараах бүртгэлийн өдөр 2020 оны 4 сарын 8-ны өдөр байх юм. Улмаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү ногдол ашгийг шилжүүлэн хувьцаа эзэмшигчдэд хуваарилагдаж эхлээд байна.

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулъя. Ард Кредит ББСБ ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2019 оны зорилтуудын талаар илтгэлийг Компанийн тухай хууль, Ард Кредит ББСБ ХК-ийн дүрмийн хүрээнд ТУЗ-өөр хэлэлцэн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна. Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь тайлант онд тус компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. ТУЗ-өөс баталсан 2019 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь технологийн шинэчлэлт, сайжруулалтад хөрөнгө оруулж, Ард Апп-ыг шинэчлэн сайжруулах, үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжин тэлэх, компанийн засаглалыг сайжруулах, холбогдох хууль

тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах байлаа. 2019 онд Ард Кредит ББСБ ХК-ийн нийт актив 23.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 120.5 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд оны эцсийн байдлаар зээлийн багц 18.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2019 оны эхэнд баталсан төсвийн дагуу компани 2.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд уг төлөвлөгөөг 10% давуулан биелүүлж 2.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Үйл ажиллагааны хувьд дараах гол ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд: 2019 оны I улиралд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалдаг хувьцаат компани болов. Ард Апп-ын II хувилбарыг танилцуулав. Ард Аппыг хагас сая орчим хүн татан авч, бид 2019 онд нийт 75 мянган зээлийн олголт хийлээ. Оны эхэнд Ард Кредит 800-н зээлдэгчтэй байсантай харьцуулбал бидний ажлын цар хүрээ ямар хэмжээнд хүрч өөрчлөгдөж байгааг харж болно. Олон нийтэд нээлттэй хувьцаат компани болж, хөрөнгийн зах зээл дээр хувьцаагаа арилжаалж эхэлсний хувьд холбогдох хууль, журмын дагуу өөрчлөн байгуулагдсан даруйдаа компанийн засаглалтай холбоотой дүрэм, журмыг шинэчлэн батлуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэлээ. Тайлант онд ТУЗ нийт 4 удаа хуралдаж, хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2 удаа амжилттай зохион байгууллаа. Монголбанкны зүгээс тавьсан шаардлагын дагуу бид Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргав. Компанийн үйл ажиллагаа тэлж, бүтээгдэхүүн үйлчилгээ шинэчлэгдэхийн хэрээр харилцагч нартаа хүрч үйлчлэх шаардлагатай болдог. Тиймээс Монгол Шуудан ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласнаас гадна Харилцагчийн Үйлчилгээний Төвийг нийт 20 гаруй ажилтантайгаар шинээр байгууллаа. Ард Кредитэд анх 2013 онд хөрөнгө оруулахаас эхлээд Ард Санхүүгийн Нэгдэл дор өөрчлөн байгуулах, ребрендинг хийх ажлыг хариуцаж, компанийг удирдаж ирсэн, Гүйцэтгэх Захирал Ч. Ганзориг 2019 оны 7 сард өөрийн хүсэлтээр ажлаа хүлээлгэж өгөв. 2019 оны сүүлчийн хагаст Гүйцэтгэх Захирлын Үүрэг Гүйцэтгэгчээр Г.Сүхбаатар томилогдон ажиллалаа. Монгол Шуудан ХК-ийн Дэд Захирлаар ажиллаж байсан Г.Тэлмэнг Ард Кредитын Гүйцэтгэх Захирлаар томилох тухай шийдвэрийг гаргав. Иймд Ард Кредитын гүйцэтгэх удирдлага 2019 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байна.

Хурал даргалагч О.Одбаяр: ТУЗ-ийн хараат бус гишүүн, Дотоод аудитын хорооны дарга Б.Ганбат 2019 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах асуудлыг танилцууллаа. Ингээд дараагийн хэлэлцэх асуудалдаа орё. Дараагийн хэлэлцэх асуудал болох Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайланг болон санхүүгийн тайланг танилцуулах асуудлыг танилцуулна уу хэмээн Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнг урья.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Манай хувьцаа эзэмшигчид Г.Тэлмэн захирлын тайланг сонсохоос өмнө өнгөрсөн жил ТУЗ-ийн зүгээс гаргасан хамгийн чухал шийдвэрүүдийн нэгийг танилцуулья. Манай компанийн үйл ажиллагааг эхнээс нь удирдаж байсан Ч.Ганзориг захирал оны дундаас өөрийн хувийн ажилдаа төвлөрч ажиллахаар ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан. Энэ асуудал өмнө нь ТУЗ-аар хэлэлцэгдэж байсан бөгөөд тухайн үед Гүйцэтгэх захирлаар ажиллах бэлэн боловсон хүчин байгаагүй тул ТУЗ-ийн дарга би оны II хагасаас үйл ажиллагаа, зээлийн албыг удирдан ажиллаж байгаа Г.Сүхбаатартай хамтран ажиллах шаардлага гарсан. ТУЗ-ийн зүгээс Ч.Ганзоригт ТУЗ-ийн гишүүнээр үлдэх, компанийн зөвлөхөөр ажиллах хүсэлт гаргасан. ТУЗ-ийн зүгээс оны эхнээс эхлэн шинэ боловсон хүчин багаа бэлдэх ажлыг давхар хийж эхэлсэн бөгөөд Монгол Шуудангийн дэд захирлаар ажиллаж эхэлсэн Г.Тэлмэнг Гүйцэтгэх захирлаар ажиллах санал тавьсан. Улмаар 2020

оны эхээр Гүйцэтгэх захирлаар ажиллах тохиролцоог хийж чадсан. ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх захирлаар Г.Тэлмэнд маш хурдан ажилдаа дадлагажих үүрэг өгсөн. Үүнтэй зэрэгцээд Ковид 19 тахлын үед ажлыг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах шаардлага гарсан. Бид Г.Тэлмэнтэй хамтран ажиллаж эхэлсэндээ маш сэтгэл хангуулан байгаа. Бид 2 удаагийн ТУЗ-ийн хурлаар төсвийн тодотгол хийж, хийх ажлыг тохиролцож албан ёсоор ажлыг хүлээлгэж өгөөд байна. ТУЗ-ийн хувьд Гүйцэтгэх захирлыг томилох, цалин урамшууллыг тогтоох, шаардлагатай бол чөлөөлөх үндсэн чиг үүрэгтэй. Энэ шилжилтийн үед ТУЗ-ийн зүгээс хангалттай сайн ажилласан гэж дүгнэж байна. Ингээд Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнг урья.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: ТУЗ-ийн дарга Ч.Ганхуягтаа баярлалаа. Ард Кредит ББСБ ХК-ийн нийт хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүд, Хурал даргалагч, менежментийн багийн гишүүд та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Миний хувьд ажлаа хүлээж авсантай холбогдуулан компанийн 3-5 жилийн стратеги, концепцийг тодруулах, бизнес процессыг сайжруулах, Ковид 19-ын үед яаралтай авч хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгээд байна. 2019 оны хувьд Ард Кредит ББСБ ХК-ийн хувьд маш том үсрэлт хийсэн жил байлаа. Хэлэлцэх асуудлыг танилцуулахаас өмнө 2018 болон 2019 оны үзүүлэлтүүдийг харьцуулан танилцуулья. 2018 оны эцсийн байдлаар хүний нөөц 21 байсан бол 40 болж нэмэгдсэн, цэвэр ашгийн хувьд 2018 оны 0.3 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2019 оны эцсээр 2.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. 2018 онд санхүүжилт 6.2 тэрбум төгрөг, нийт хөрөнгө 10.5 тэрбум төгрөг, 7.6 тэрбум төгрөг, олгосон зээлийн хэмжээ 10.8 тэрбум төгрөг байсан бол 2019 онд санхүүжилт 10.9 тэрбум төгрөг, нийт хөрөнгө 23.1 тэрбум төгрөг, зээлийн багц 18.4 тэрбум төгрөг, олгосон зээлийн хэмжээ 42.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулья. “Бичил Санхүүгийн Төв”-өөс зохион байгуулсан Олон улсын хурлын Алтан спонсороор ажиллаж, Ард Апп-ыг олон улсын хөрөнгө оруулагчдад албан ёсоор танилцуулав. Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг үүрэгт ажлаа хүлээлгэн өгч, Г.Сүхбаатар гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдов. Монголбанкинд Цахим мөнгөний тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргалаа. 2019 оны 9 сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулж, Компанийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлуулав. Санхүүгийн Зохицуулах Хороонд хаалттай бонд гаргах хүсэлт гаргаж, 2 тэрбум төгрөгийн зөвшөөрөл авлаа. Ард Апп-ын 3 дахь хувилбарыг Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2020 Чуулга уулзалтын үеэр олон нийтэд танилцууллаа. Шинэ төрлийн Коронавирус тархсантай холбогдуулан ажлын байрны тусгай горим баталж, зайнаас ажиллах зохицуулалт хийх, он-лайн горимоор хуралдах зэргээр цаг үеийн шийдвэрийг түргэн шуурхай гаргаж ажиллав. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй BEST хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ-тай 2020 оны 4 сарын 9-ний өдөр хамтран ажиллах санамж бичиг зурав. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлыг 1 удаа, ээлжит бус хурлыг 1 удаа тус тус зохион байгууллаа. Монгол HD TV-тэй хамтран Ард Апп-ын III хувилбарын давуу талыг харуулсан контент бүтээв. Компанийн 3-5 жилийн стратеги, концепцийг боловсруулах ажлын хэсгийг байгууллаа. Та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн бүтцийг танилцуулья. Одоогоор нөлөө бүхий 12 хувьцаа эзэмшигч байгаа бөгөөд IPO хийсний дараа нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 1432 байсан бол, 2020 оны I улирлын байдлаар хувьцаа эзэмшигчдийн тоо 1683 болж хувьцаа эзэмшигчдийн тархалт нэмэгдсэн байна. Оны эхэнд ТУЗ-аас компанийн бүтцийг баталсан. Бүтцийн хувьд Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх Хороод Гүйцэтгэх захирал, үйл ажиллагааны чиглэлээр 4 алба зохион байгуулсан бөгөөд Ард Санхүүгийн Нэгдлээс аутсорсингоор зарим нэгэн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөгөө авч ажиллаж байна.

2019 оны санхүүгийн тайланг танилцуулья. 2019 оны жилийн эцсээр нийт хөрөнгө 23.1 тэрбум байсан бол оны эхний улирлын байдлаар 25.1 тэрбум төгрөгт, зээлийн багц 18.4 тэрбум төгрөг байсан бол оны эхний улирлын байдлаар 18.9 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. 2018 онд санхүүжилт аваагүй бол 2019 онд Японы Крауд Кредит сангаас 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилт татсан. Ард Апп нэвтэрсэнтэй холбогдуулан онлайн зээл нийт зээлийн багцын 82 хувийг эзэлж байгаа бол нийт зээл олголт 42.8 тэрбум төгрөгт хүрч нийт зээл олголтын тоо 76,273-т хүрсэн байна. 2019 оны санхүү байдлын тайланг танилцуулья. Нийт хөрөнгө 23 тэрбум төгрөг хүүний орлого 18 тэрбум төгрөг байсан бөгөөд Хөрөнгийн биржийн I ангиллын хувьцаанд хөрөнгө оруулалт хийсэн байна. 2019 онд хүү болон түүнтэй адилтгах орлого 3.8 тэрбум төгрөгт хүрч татварын дараах ашиг 2.1 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Монголын Хөрөнгийн Бирж дээр нээлттэй хувьцаат компани болон 5.3 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлснээс 1 хувийг хэвлэл, танилцуулгын зардалд, 5 хувийг мэргэжлийн байгууллагуудын шимтгэл хураамжид, 4 хувийг маркетингийн зардалд, 90 хувийг зээл олголтын хийхэд тус тус зарцуулсан байна. Хувьцааны арилжааны хувьд нийтдээ 2.7 тэрбум төгрөгийн арилжаа зах зээл дээр хийгдсэн бөгөөд хувьцааны ханш 65-аас 88 төгрөгийн хооронд хэлбэлзсэн байна. Компанийн үнэлгээ оны эцсээр 22.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Та бүхэндээ 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцууллаа.

Хурал даргалагч О.Одбаяр: Хэлэлцэх асуудлуудыг танилцуулж дууслаа. Танилцуулсан асуудлуудтай холбоотой асуулт, хариултын үе эхлэхэд бэлэн болсон байна. Асуулт, хариултын үе эхэлснийг мэдэгдье

Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал Г.Сүхбаатар: Хувьцаа эзэмшигчдээс нилээд асуултууд ирүүлсэн байна. Асуултуудыг багцлаад явья. Хувьцаа эзэмшигчээс маань 2020 онд орон нутагт үйлчилгээгээ нэвтрүүлэх үү? Гэсэн асуулт ирсэн байна.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Компани маань өнгөрсөн жил Монгол Шуудан ХК-тай стратегийн түншлэлийн ажиллагааны хүрээнд Дархан, Эрдэнэт хотод үйлчилгээгээ нэвтрүүлээд байна. Энэ онд орон нутагт үйл ажиллагаагаа хүргэхээр төлөвлөсөн боловч халдварт өвчинтэй холбоотойгоор хойшлогдоод байна. Гэхдээ оны эцэст багтаан Монгол Шуудан ХК болон Ард Даатгал ХК-тай стратегийн түншлэлийн гэрээний хүрээнд үйл ажиллагаагаа хүргэх болно.

Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал Г.Сүхбаатар: Цахим мөнгөний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах шаардлагатай байна. Цахим мөнгөтэй холбоотой кредит карт гаргах уу? Энэ асуултад миний зүгээс хариулт өгье. Монголбанкинд цахим мөнгөний тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлт гаргасан бөгөөд энэ сардаа хойшилвол дараа сардаа багтан тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудал шийдвэрлэгднэ. Дараагийн асуултыг Ц.Ганбат гэж хувьцаа эзэмшигч ирүүлсэн байна. Нилээн олон асуулт ирүүлсэн байгаа тул багцлаад асууя. 2019 онд оны эхэнд ногдол ашгийг нэгж хувьцаанд 4.3 төгрөг олгоно гэж байсан боловч яагаад 3.9 төгрөг болсон бэ?

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Хуулийн хүрээнд 2020 оны 2 сарын 19-ний өдөр ногдол ашиг тараах шийдвэр гаргах эцсийн өдөр байсан бөгөөд тухайн үед аудитлагдсан тайлан гараагүй байсан. 2019 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлангаар ашгийн хэмжээнд өөрчлөлт орсон учир тараах ногдол ашгийн хэмжээнд өөрчлөлт орсон.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: Ногдол ашиг бизнес төлөвлөгөөнд тусгагдснаас багаар олгогдсон байгаа. Манай бизнес төлөвлөгөөнд тусгаснаас IPO хийх хугацаа хойшилсон учир бизнес төлөвлөгөө хойшилсон байна.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Анх ТУЗ-өөс зарласан ногдол ашгийн хэмжээ, 3 сарын сүүлээр ногдол ашгийн хэмжээ буурсан зөрүүн дээр асуулт байсан гэж ойлгож байна. Энэ хугацаанд аудит хийгдсэн. Аудитлагдсан тайлангаар манай дээр байсан 200 сая гаруй төгрөгийн зээлийн ангиллыг өөрчилж, эрсдэлийн сан байгуулснаар ашиг буурсан. Үүнтэй холбогдуулан тараах ногдол ашгийн хэмжээнд өөрчлөлт орсон. Энэхүү зээлийн эргэн төлөлт хийгдвэл 2020 оны ашигт бүртгэгднэ.

Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал Г.Сүхбаатар: Д.Мөнхбаяр хувьцаа эзэмшигчээс хувьцааны үнэтэй холбоотой асуулт ирсэн байна. Хувьцааны үнэ яагаад анхдагч зах зээлийн арилжааны үнэд хүрэхгүй байгаа вэ? Ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Компанийн хувьцааны ханшид компанийн үйл ажиллагаа мөн гадаад хүчин зүйлийн нөлөөлөл хамаарна. Компанийн менежментийн багаас компанийн ашгийг нэмэгдүүлэх дээр төвлөрч ажиллаж байна. Оны эхнээс гадаад хүчин зүйлийн нөлөөлөл халдварт өвчнөөс шалтгаалан нэмэгдэж, макро эдийн засгийн хүрээнд уналт ажиглагдаж байгаа. Гэсэн хэдий ч компанийн менежментийн багийн зүгээс үйл ажиллагаагаа ашигтай, тасралтгүй байлгахад анхааран ажиллаж байна.

Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал Г.Сүхбаатар: 1072 хувьцаа Ард Апп дээр харагдах боломжтой юу гэсэн асуулт ирсэн байна.

Б.Өлзийбаяр: Одоогийн байдлаар 1072 хувьцааны тоо үнэт цаасны компаниуд дээр харагдахгүй байгаа. Эрдэнэс таван толгой компанийн арилжаа хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж эхлээгүй байгаа тул брокерийн данснууд дээр харагдах боломжгүй байгаа юм.

ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг: Бид анх IPO хийхдээ хувьцаа бол тогтмол өгөөжтэй санхүүгийн хэрэгсэл биш хувьцаа бол тухайн компанид итгээд хөрөнгө оруулалт хийж байгаа явдал болох талаар хувьцаа эзэмшигчиддээ хэлж байсан билээ. Хувьцаа нь урт хугацааны хөрөнгө оруулалт тул тул түр хугацааны хөрөнгө оруулалт гэж ойлгох нь өрөөсгөл юм. Манай хувьцааг богино хугацаанд эргэлдүүлж ашиг хийх зорилготой хүмүүс орж ирсний улмаас хувьцааны ханш унасан. Одоо эдийн засаг хямралд үүсээд байгаа энэ үед хувьцааны ханшнаас илүүтэй, компанийн үйл ажиллагааг сайжруулах, уг үеийг бага хохиролтой илүү их ашигтай ажиллах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал Г.Сүхбаатар: Хувьцаа эзэмшигч Т.Баасанжаваас Ковидтой холбоотой боловсруулсан төлөвлөгөө байгаа юу гэсэн асуулт ирүүлсэн байна.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Ковидын тархалт маш түргэн, хурдацтай байна. Бид хамгийн түрүүнд бизнесийн ажиллагаагаа тасралтгүй байлгах арга хэмжээг авч ажиллагсдынхаа эрүүл мэндэд анхаарч байна. Нийт ажиллагсдын 50 хувь нь гэрээс ажиллах боломжийг олгосон. Бид харилцагчидтайгаа илүү ойр ажиллаж, судалгаа хийж байгаа бөгөөд хөл хорио тогтоосонтой холбоотой харилцагчийн үйлчилгээний төвөөр дамжуулан үйл ажиллагаагаа дижиталаар явуулж байна. Мөн эдийн засаг хэвийн болсон тохиолдолд хэрхэн ажиллах талаар бизнесийн төлөвлөгөө

гаргасан бөгөөд гаргасан зээлээ даатгах, бонд итгэлцэл дээр даатгал хийлгэх зэргээр эрсдэлээ бууруулах тал дээр анхаарч ажиллаж байна.

Хурал даргалагч О.Одбаяр: Асуулт, хариултын үе дууслаа. Хэрэв хариулж амжаагүй асуулт байвал Ард Кредит ББСБ ХК-ийн Менежментийн багийн гишүүд нөхөж хариултыг хүргүүлнэ үү. Хурлын дэгийн дагуу Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлийг батлах асуудлын хүрээнд санал хураалт явуулья.

Хурал даргалагч О.Одбаяр: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүн гарсан байна. Ингээд санал, хураалтын дүнг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Г.Алтансүхийг урьж байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулья. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг танилцуулья.

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтын дүнг танилцуулах нь:

Зөвшөөрсөн 236,663,426 ширхэг буюу нийт санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчдийн 99.19 хувийн саналаар тайланг батлав.

Тооллогын комиссын дарга тооллогын комиссын тогтоолыг Хурлын даргад хүлээлгэн өгөв.

Хурлын даргалагч О.Одбаяр: Тооллогын комисстоо баярлалаа. Өнөөдрийн Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай явагдаж өндөрлөлөө. Тооллогын комиссын танилцуулсан тайланд үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг танилцуулья. 2020 оны 4 сарын 27-ны өдөр, №01/20, Улаанбаатар хот, **Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай:** Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2020 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 20/01 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ард Кредит ББСБ ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдээ сайн сайхан бүхнийг хүсье. Хурал хаасныг үүгээр мэдэгдье гэснээр 16.00 цагт хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА
О.ОДБАЯР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН
М.МӨНХСҮРЭН



②